



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 401

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.1.3 дахь заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 01/3762 дугаар албан бичгээр ирүүлсэн санал, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 05/11637 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Эрдэнэсант АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай:

1.1.“Эрдэнэсант АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлаар Аюургинагийн Баясгаланг томилох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.

1.2.“Эрдэнэсант АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал А.Баясгалантай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг хууль тогтоомжийн дагуу байгуулж ажиллах.

2.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ